

# NEAR News

Нэг Зүүн хойд Ази- Нэг хамтын нийгэмлэг NEAR | One Northeast Asia Region, One Community NEAR

2017 оны 3-4 сар

Vol. 73



Дунгун ордон ба Вольжи цөөрөм/БНСУ, Гёнжү хот

## Энэ сарын мэдээ

NEAR Холбооны үйл ажиллагаа | Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ  
Гишүүн орон нутгуудын мэдээ | Гишүүн орон нутгуудад зохиогдох олон улсын арга  
хэмжээ(3-4 сар)

## Эдийн засгийн булан

Япон улсын Шиманэ муж

## Тусгай нийтлэл

Ази Номхон далайн хотуудын дээд хэмжээний хурал (2017 APCS)  
4 дэх удаагийн эссэ бичлэгийн шагналт байрын бүтээлээс толилуулах нь



Зүүн Хойд Азийн Нутгийн  
Захиргаадын Холбоо

The Association of Northeast Asia Regional Governments

# NEAR News

NEAR News сэтгүүл нь гишүүн байгууллагуудын мэдээг дамжуулах, харилцан мэдээлэл солилцох албан ёсны хэвлэл юм. NEAR Холбооны гол үйл ажиллагаа, гишүүн орон нутгуудын мэдээ, төрөл бүрийн нийтлэл, зарлал зэргийг голчлон нийтэлдэг 2 сар тутмын хэвлэл бөгөөд гишүүн орон нутаг, холбогдох байгууллагуудад үнэгүй тараадаг. Мөн сэтгүүлийг онлайн хэлбэрээр Холбооны вэбсайтад тавьдаг. NEAR News сэтгүүл гишүүн орон нутгийн нийтийн бүтээл бөгөөд Зүүн хойд Азийн бүсийг сонирхогч хэн бүхэнд нээлттэй. Сэтгүүлд чанартай нийтлэл, шинэ санаа оноо тусгахыг хүсвэл бидэнд хандана уу.



6



12



15



Vol. 73



Масленица 1919 он, Зураач Костодиев



**Зүүн хойд Азийн 6 улс(Монгол, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос)-ын 82 орон нутаг(77 гишүүн орон нутаг, 5 ажиглагч статустай орон нутаг)-аас бүрдэх Зүүн хойд Азийг төлөөлөх орон нутгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны олон улсын байгууллага юм.**

Тус Холбоо хамтын хөгжил цэцэглэлт гэсэн үндсэн үзэл санаан дор Холбооны үндсэн дүрмийг баталж, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцаа, худалдаа, боловсрол соёлын харилцаа, байгаль орчин, гамшгаас сэргийлэх, хилийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, далай загасны аж үйлдвэр, эрдэс баялаг, зохицуулалт, хүүхэд эмэгтэйчүүд, эмчилгээ, газар тариалан зэрэг төрөл бүрийн салбарт өргөн харилцаа, хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна.

Европын орон нутгийн хамтын ажиллагааны төлөөлөх байгууллага АЕР(Европын Нутгийн Захиргаадын Холбоо), R20(Уур Амьсгалын Өөрчлөлтийн Эсрэг Үйл Ажиллагааны Холбоо), ICLEI(Дэлхийн Нутгийн Захиргаадын Холбоо)

зэрэг олон улсын байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоох, хамтын төсөл явуулах зэргээр идэвхтэй харилцан Зүүн хойд Ази төдийгүй дэлхийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагааг явуулахад хичээн чармайж байна

## **NEAR Холбооны үүд хаалга үргэлж нээлттэй байна**

Зүүн хойд Азийн бүсэд байршилтай, Холбооны үндсэн үзэл санаатай санал нэг орон нутгийн захиргаад тус Холбооны Бүгд хуралд оролцож, гишүүнээр элсэн орж болно(Зүүн хойд Азиас бусад Азийн бүсийн орон нутгууд сурвалжлагч гишүүнээр элсэж болно).



**Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын Холбоо**

The Association of Northeast Asia Regional Governments

## NEAR Холбооны үйл ажиллагаа

### Холбооны 2016 оны үйл ажиллагааны тайлан хэвлэгдэн гарав.



Тус Холбооны Хэрэг эрхлэх газраас өмнөх жилийн үйл ажиллагааг нэгтгэн тайлан гаргав. Уг тайланд 2016 онд болж өнгөрсөн Бүгд хурал, NEAR-Олон улсын форум, салбар хороодын үйл ажиллагаа, гишүүн орон нутгуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд зохион байгуулсан Зүүн хойд Азийн залуу удирдагч форум, хүүхэд сурагчдад зориулсан 4 дэх удаагийн эссэ бичлэгийн уралдаан зэргийн талаар оруулсан болно. Монгол, орос, солонгос, хятад, япон, англи нийт 6 хэлээр гарган гишүүн орон нутгууд болон холбогдох байгууллагуудад түгээв.

### Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал болно.

Тус Холбоотой хамтарч ажилладаг гишүүн орон нутгийн холбогдох хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтнүүдэд зориулсан хурлыг 4 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд БНСУ-ын Жэжү хотод зохион байгуулна. Холбооны Хэрэг эрхлэх газрын 2016 оны ажлын тайлан, 2017 онд хийх ажлын танилцуулга, гишүүн орон нутгуудын гол хэрэгжүүлж буй бодлого, харилцаа хамтын ажиллагааны төслийн талаар илтгэл тавигдахаас гадна Холбооны үйл ажиллагаатай холбогдох санал гаргах, гишүүний татварын журам, салбар хороодыг ажиллуулах тухай журамд өөрчлөлт оруулах зэрэг дотоод асуудлын талаар хэлэлцэх юм. Хурлын талаарх дэлгэрэнгүй төлөвлөгөөг гишүүн орон нутгуудад мэдэгдэх болно. Нөгөөтэйгүүр жил бүр болдог уг хуралд өнгөрсөн хугацаанд 800 гаруй хүн оролцсон байна.

### Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудад зориулсан 5 дахь удаагийн эссэ бичлэг, гар зураг, постерийн уралдаан зохион байгуулна.

Зүүн хойд Азийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын талаарх хүүхэд залуучуудын сонирхлыг нэмэгдүүлэх, гишүүн орон нутгуудын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 5 дахь удаагийн эссэ бичлэг, гар зураг, постерийн уралдааныг 4 дүгээр сард зарлана. Өмнөх жилийн адилаар эссэ бичлэг, гар зураг, постер гэсэн төрлөөр бүтээлийг хүлээн авах ба дэлгэрэнгүй төлөвлөгөөг 4 дүгээр сард гишүүн орон нутгуудад танилцуулах болно.

## Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ

### Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Хунан мужид айлчлав.



12 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд тус Холбооны 12 дахь удаагийн тэргүүлэгч болох БНХАУ-ын Хунан мужид Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон ажлын айлчлал хийв. Айлчлалын зорилго нь Хунан муж цаашид Холбооны тэргүүлэгчээр 2 жил ажиллахтай холбогдуулан мужийн удирдлагуудтай уулзаж үйл ажиллагааны талаар хэлэлцэх байв. Хунан мужийн Захирагчийн 1-р орлогч Чон Шиан Чен Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Воныг хүлээн авч уулзахдаа “Хунан мужийн захиргаанаас ЗХАНЗХ-той харилцах хэлтсийг байгуулах зэргээр Холбооны тэргүүлэгчийн үүргийг гүйцэтгэхийн тулд бэлтгэл ханган ажиллаж байгаа бөгөөд олон салбарт харилцаа, хамтын ажиллагаа явуулахыг хүсч байна” гэв.

Хариуд нь Ерөнхий нарийн бичгийн дарга “Хунан муж Холбооны тэргүүлэгчийн үүргийг гүйцэтгэхэд дээд зэргээр тусалж дэмжихээ илэрхийлээд цаашид ажлын хувьд холбоотой байж, гишүүн орон нутаг хоорондын харилцааг бэхжүүлэхэд хичээх болно” гэв.

### Холбооны ХЭГ-ийн төлөөлөл Ази Номхон далайн хотуудын аялал жуулчлалын хөгжлийн байгууллага (ТРО)-д айлчлав.

2016 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Холбооны ХЭГ-ийн Төлөвлөлт, Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Гүн Нам Вон тэргүүтэй төлөөлөгчид аялал жуулчлалын салбарын олон улсын байгууллагатай харилцаа тогтоон мэдээлэл солилцох үүднээс Пусан хот дахь Ази Номхон далайн хотуудын аялал жуулчлалын байгууллага(ТРО)-д айлчлав. ЗХАНЗХ-ны харьяа Аялал жуулчлалын хороо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Гёнсанбүг мужийн Андун хотноо “Зүүн хойд Азийн орнуудын аялал жуулчлалын хамтын ажиллагаа ба хөгжил” хэмээх сэдвээр олон улсын форум зохион байгуулсан юм.

Ази Номхон далайн хотуудын аялал жуулчлалын хөгжлийн байгууллага

нь хотуудын хамтын оролцоотой олон улсын байгууллага болохын хувьд тухайн бүс нутгийн аялал жуулчлал, аж үйлдвэрийн салбарыг идэвхжүүлж, хөгжүүлэхийн тулд аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг шинээр гаргах болон төрөл бүрийн хөтөлбөр, үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд цаашид форум хамтран зохион байгуулах талаар судлахаар болов.

### **ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газрын гадаад ажилтнууд Пухан хотын ахлах сургуулийн сурагчдад өөрийн улсын соёлыг сурталчлан таниулах хичээл заав.**

12 дугаар сарын 21-ний өдөр ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газарт Монгол улс болон БНХАУ-аас томилогдон ажиллаж буй төрийн албан хаагчид Пухан хотын ахлах сургуулиар айлчилж өөрийн улсын соёл, ёс заншлын талаар танилцуулав.

Тухайлбал тус сургуулийн дэргэдэх "Олон улстай танилцах клуб"-ын үйл ажиллагаанд оролцож, клубын гишүүд болон олон улсын асуудлыг сонирхон судалдаг 30 гаруй сурагчид өөрийн улсын тухай мэдээлэл өгч танилцуулсан юм. Дараагаар нь сурагчид өөрсдийн сонирхсон зүйлийг асууж, асуулт хариултын бяцхан тэмцээн зохион байгуулан мэдлэгээ бататгалаа. Тус газраас цаашид ч Пухан хотын хүүхэд залуучуудад олон улсын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.



### **Монгол улсаас БНСУ-ын Пусан хотод суугаа Консулын газарт айлчлав.**



2017 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Холбооны ХЭГ-ийн төлөөлөл Монгол улсаас БНСУ-ын Пусан хотод суугаа Консулын газарт айлчлан тус газрын консулд бараалхав. Тухайлбал ЗХАНЗХ-ны ХЭГ-ийн Олон улс, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Гү Жа Хи консул Д.Бямбадоржид бараалхахдаа тус Холбоонд Монгол улсын нийт аймаг, нийслэл гишүүнээр элссэн бөгөөд Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, төрөл бүрийн мэдээлэл авч, тэргүүний туршлагаас судалж байдгийг онцлон тэмдэглэв.

Монгол улсаас БНСУ-ын Пусан хотод суугаа консул Д.Бямбадорж тус Холбооны ХЭГ-т шаардлагатай үед туслаж дэмжих болно гээд ирэх 2 дугаар сард Пухан хотод ажлын айлчлал хийнгээ Холбооны ХЭГ-т айлчлах боломжтойгоо илэрхийлэв.

Дашрамд Монгол улсаас Пусан хотод суугаа Консулын газрын тойрогт Жолланам муж, Гёнсанбүг муж, Гёнсаннам муж, Пусан, Тэгү, Гуанжү, Ульсан хотууд багтдаг аж.

### **Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Вьетнам улсаас БНСУ-д суугаа элчин сайдад бараалхав**

2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Вьетнам улсаас БНСУ-д суугаа элчин сайд Пам Хүжид бараалхан ЗХАНЗХ болон тус элчин сайдын яам хооронд хамтарч ажиллах арга замын талаар хэлэлцэв. Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Холбооны хүрээнд сурвалжлагч гишүүн элсүүлэх болсонтой холбогдуулан Зүүн хойд Азиас бусад Азийн бүсийн орон нутгуудыг сурвалжлагч гишүүнээр элсэж болох тухай тайлбарлав. Мөн Вьетнам улсын орон нутгууд ЗХАНЗХ-гоор дамжуулан Зүүн хойд Азийн орон нутгуудтай харилцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломжтойг дурдав.

Энэ жил Вьетнам улсын Хошимин хотноо "Гёнжү-Хошимин экспо" болох тул цаашид хоёр орны харилцаа идэвхжих төлөвтэй байна. Вьетнам улсын Хошимин хот тэргүүтэй орон нутгууд ЗХАНЗХ-ны сурвалжлагч гишүүнээр элсэхэд элчин сайдын зүгээс тусалж дэмжихийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүсэв. Хариуд нь элчин сайд Пам Хүжи "Вьетнам улсын орон нутгууд Холбооны үйл ажиллагаанд оролцон улмаар гишүүн орон нутгуудтай идэвхтэй харилцааг явуулбал сайшаалтай юм. Шаардлагатай үед тусалж дэмжихэд бэлэн байна" гэв. (Вьетнам улс 58 муж, 5 бие даасан хоттой)



### **Холбооны ХЭГ-ийн төлөөлөл Пусаны Олон улсын харилцааны санд айлчлав.**

Холбооны ХЭГ-ийн төлөөлөл Пусаны Олон улсын харилцааны санд айлчлан Холбооны зүгээс 2017 онд шинээр хэрэгжүүлэх хөтөлбөртэй холбогдуулан тус сангийн олон улсын харилцааны үйл ажиллагаа, хөтөлбөр ажлын талаар сонирхож туршлага судлахаас гадна харилцан санал бодлоо солилцов. Тус сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга Алок К Рой "ЗХАНЗХ-гоор дамжуулан цаашид Пусан хот орон нутгуудтай харилцаа явуулж, мөн хоёр байгууллагын хооронд нягт хамтарч ажиллана гэдэгт найдаж байна" гэв.

# Гишүүн орон нутгуудын мэдээ

## Хунан муж-БНХАУ

**Жөнжөү 2017-Олон улсын хөрөнгө оруулалт, худалдааны уулзалт болно.**



Жөнжөү-Олон улсын хурлын төв

3 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд энэхүү уулзалт болно. Энэ нь Хэнан мужийн захиргаа, Хятадын худалдааг идэвхжүүлэх хороо, Хятадын гадаадтай харилцах нийгэмлэгээс хамтран зохион байгуулдаг хамгийн том олон улсын эдийн засаг, худалдааны арга хэмжээ юм. Мөн Хэнан мужийн гадаад харилцаа, аж үйлдвэрийн салбарт уг арга хэмжээ ач холбогдолтой байдаг. Өнгөрсөн хугацаанд 10 удаа зохион байгуулагдсан бөгөөд дотоод гадаадаас олон хүн оролцож, хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж, олон гэрээ байгуулсан. Энэхүү гэрээ төсөл нь Хэнан мужийн хөгжлийг эрчимжүүлсэн төдийгүй Хятад болон гадаадын бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгодог. Арга хэмжээний үеэр Хэнан мужид өвөг дээдэстээ зориулан тахилга үйлдэх арга хэмжээ болох тул нутгийн соёлтой танилцах боломжтой.

## Киото муж-Япон улс

**Цайны үзэсгэлэн болно.**



Киото мужийн үжи цайг сурталчлан таниулахын зэрэгцээ нутгийн эдийн засгийг эрчимжүүлэхийн тулд 2017 оны 4 дүгээр сараас эхлэн 1 жилийн турш мужийн өмнөд нутгийн 12 газарт энэхүү үзэсгэлэнг зохион байгуулна. 4 дүгээр сарын 1, 2-ны өдрүүдэд сакура цэцгээр алдартай Сэвуари нутагт “Сакура” үдэшлэгээр нээлтийн ажиллагааг эхэлнэ. 10 дугаар сард премиум үжи цайг амтлах цайны газар ажиллуулах

зэрэг соёлын хөтөлбөрийг зохион байгуулна. 11 дүгээр сард цайны аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд бизнес уулзалт, дотоод гадаадын цайны бизнес эрхлэгчдэд зориулсан арга хэмжээг зохион байгуулна. Үүнээс гадна Киото мужийн өмнөд нутгаас авахуулаад Японы бусад нутгуудын өвийг нэг дор цуглуулах “Японы өвийн хурал” зохион байгуулна. Тус муж үжи цайг нутгийн брэнд болгон дотоод гадаадад цайгаар дамжуулан нутгаа сурталчлан таниулахад анхаарч байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://ochahaku.kyoto> сайтаас авна уу.

## Тоттори муж-Япон улс

**Тоттори мужид зорчигчдын тоог нэмэгдүүлнэ.**



2001 оноос Тоттори мужийн Юнаго хот БНСУ-ын Инчон хотын чиглэлд Солонгосын АСИАНА компани нислэг үйлдэх болсон бөгөөд 2009 онд мужийн Сакайминато хот, БНСУ-ын Дунхэ хот, ОХУ-ын Владивосток хотыг холбох аялагчдын усан онгоц явах болсон. Ингэснээр Тоттори муж Зүүн хойд Азийн бүсийн харилцааны гүүр болоход чухал үүрэгтэй болсон. 2016 оноос Тоттори муж жуулчдыг олноор татахын тулд дангаар аялагч нэн ялангуяа залуу жуулчдад зориулж олон нийтийн сүлжээгээр сурталчилгаа явуулахын зэрэгцээ аялалын хөтөлбөр маршрут, Тоттори мужийн хоолны тухай мэдээлэл бүхий лавлагаа гарган тарааж байна. Мөн 2016 онд Юнаго-Гонконгийн чиглэлд Гонконгийн агаарын тээвэрлэгч компани нислэг үйлдэх болсон. Гонконгд Тоттори мужийг таниулахын тулд блог, аялалын сэтгүүл, телевизийн нэвтрүүлгийг ашиглан нутгаа сурталчлах болсон.

Түүнээс гадна сүүлийн үед жуулчин татах идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн тод жишээ бол том оврын аялагчийн усан онгоц Сакайминато хотоор дамжин өнгөрөх чиглэлийн тээвэр хийдэг болсон бөгөөд энэ нь дотоодод чиглэсэн аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийн бодит үр дүн юм. Тоттори муж цаашид олон улсад гарах гарцыг идэвхтэй ашиглан Зүүн хойд Азийн бүсийн иргэдийн харилцан

зорчих үйл ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч байна.

## Инчон хот-БНСУ

### Хятадын цагаан сарын баярыг Инчон хотноо тэмдэглэв.



Солонгос улс дахь Хятадын соёлын төвөөс 1 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд Хятадын цагаан сарын баярыг Инчоны эдийн засгийн чөлөөт бүс ба Инчон хот дахь Хятад хотхонд зохион байгуулав. Хятад улсын Соёлын яамнаас 2010 оноос эхлэн зохион байгуулах болсон энэхүү баяр нь гадаад дахь хятад үндэстнүүдийн хамгийн том баяр юм. Энэ жил 7 дахь удаагаа болсон бөгөөд Хятадын Соёлын яам, Худалдааны хороо болон соёлын байгууллага, гадаад дахь дипломат албаны байгууллага хамтран Инчон хотод анх удаа зохион байгуулсанаар онцлог байв. Баярт зориулж Хунан мужийн биет бус соёлын өвийн үзэсгэлэн, тоглолт, яст мэлхийн ясан дээрх калиграфийн үзэсгэлэн, Хунан мужийн үндэсний хөгжмийн чуулгын тоглолт, арслант бүжгийн тоглолт, Хятад хотхон дахь парад зэрэг олон төрлийн хөтөлбөр болов. Инчон хотод энэ баярыг зохион байгуулсанаар “Хятад, Солонгос 2 улсын иргэдийн ойлголцол, нөхөрлөлийг нэмэгдүүлэх төдийгүй хоёр орны төрөл бүрийн салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй” гэж үзжээ.

## Өмнөговь аймаг-Монгол улс

### Өмнөговь аймаг, БНСУ-ын Гёнсанбүг мужтай газар тариалангийн салбарт хамтарч ажиллана.



2016 оны 12 дугаар сарын 7-8 ны өдрүүдэд БНСУ-ын Гёнсанбүг мужийн

захиргааны Глобал худалдаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ким Хан Сү тэргүүтэй айлчлалын бүрэлдэхүүн Өмнөговь аймагт хүрэлцэн ирж, аймгийн Засаг дарга Н.Наранбаатар, Засаг даргын орлогч Х.Батболд болон албаны бусад төлөөлүүдтэй уулзалт хийж, хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох, цаашид газар тариалангийн чиглэлээр хамтран ажиллах, говь нутагт тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, тус салбарын мэргэжилтэн, тариалан эрхлэгчдийг мэргэшүүлэн сургах зэрэг ажлуудыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцлоо.

## Эрхүү муж-ОХУ

### “Baikal-CeraMystica. Ice” олон улсын урлагийн арга хэмжээ болно.

Энэхүү нь Эрхүү мужийн Ольхонский дүүрэгт 2012 оноос эхлэн жил бүр уламжлал болон зохиогддог шаазан урлалын арга хэмжээ юм. Байгаль нуурын дэргэд болдог бөгөөд Оросын соёлын чухал арга хэмжээ болсон төдийгүй дэлхийд ч өндөр түвшний арга хэмжээ хэмээн тооцогддог болсон. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Оросын 15 хот ба гадаадын 13 улсын шаазан урлалын мэргэжилтнүүд олон улсын шүүгчдийн хорооны журмын дагуу мэргэжлийн чиглэлээр ур чадвараа сорьсон. Энэ жил Эрхүү хотод анх удаа “Baikal-CeraMystica.Ice ” фестивалийг зохион байгуулах ба 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 6-ны өдрийг дуустал үргэлжлэх болно. Арга хэмжээний үеэр шаазан эдлэл урлаачид бүтээлээ урлах болно. “Baikal-CeraMystica. Ice” арга хэмжээ нь Сибирийн шаазан урлалын түүхэнд тэмдэглэгдэх чухал ач холбогдолтой юм.

3 дугаар сарын 10-ны өдөр Эрхүү мужийн урлагийн музейд 5 өдрийн турш “Baikal-CeraMystica” фестивалийн бүтээлүүдийн үзэсгэлэн гарна.



# March

2017. 3

| Sunday                                                                                                                                                                                                                                                                                                        | Monday                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Tuesday                                                                              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                      |
| 5                                                                                                                                                                                                                                                                                                             | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Хёго муж/Япон улс</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Холбооны Гамшгаас сэргийлэх хорооны 15-р хурал</b></li> <li>Хэзээ : 3.6~3.8</li> <li>Хаана : Кобэ хот</li> <li>Харилцах утас : Хёго мужийн захиргааны Гамшгаас сэргийлэлт, төлөвлөлтийн хэлтэс (Т)+81-78-362-9870 (F)+81-78-362-9914</li> </ul> | 7                                                                                    |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Тоттори муж/Япон улс</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Тоттори марафон 2017</b></li> <li>Хэзээ : 3.12</li> <li>Хаана : Тоттори хот</li> <li>Харилцах утас : Марафон тэмцээнийг зохион байгуулах хороо (Т)+81-857-21-2885</li> </ul>                           | 13                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |  |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Инчон хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Инчон-Олон улсын хагас марафоны 17 дахь удаагийн тэмцээн</b></li> <li>Хэзээ : 3.26</li> <li>Хаана : Stadium Инчоны Мунхаг стадион</li> <li>Харилцах утас : (Т)+82-32-440-4952 (E)wwokkyu@koera.kr</li> </ul> | 20                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                      |
| 26                                                                                                                                                                                                                                                                                                            | 27                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                      |

# April

2017. 4

|                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                    |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Жоллабуг муж/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Жонжү-Олон улсын 18 дахь удаагийн кино фестиваль</b></li> <li>Хэзээ : 4.27~5.6</li> <li>Хаана : Жонжү хот</li> <li>Харилцах утас : Жоллабуг мужийн захиргааны Соёл, урлагийн хэлтэс (Т)+82-63-280-3381 (E) ilyeop@korea.kr</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Шаньдун муж/БНХАУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Олон улсын далбаат завьны уралдаан 2017</b></li> <li>Хэзээ : 4.28~5.1</li> <li>Хаана : Чиндао хот</li> <li>Харилцах утас : Чиндао хотын завьны уралдааны холбоо (Т)+86-532-85916115</li> </ul> |    |
| 2                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 3                                                                                                                                                                                                                                                                                                  | 4  |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Пусан хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Пусан-Нагдун голын рапс цэцгийн 6 дахь удаагийн баяр</b></li> <li>Хэзээ : 4.9~4.17</li> <li>Хаана : Дэжо-Эко парк</li> <li>Харилцах утас : Пусан хотын захиргааны Аялал жуулчлалын хөгжлийн хэлтэс (Т) +82-51-888-5054</li> </ul>        | 10                                                                                                                                                                                                                                                                                                 | 11 |
| 16                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 17                                                                                                                                                                                                                                                                                                 | 18 |
| 23/30                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 24                                                                                                                                                                                                                                                                                                 | 25 |

| Wednesday                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Thursday                                                                                                                                                                                                                                                                                                   | Friday                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Saturday                                                                                                                                                                                                                                                                                                               |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 2                                                                                                                                                                                                                                                                                                          | 3                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Дэгү хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Дэгү-Олон улсын даавууны үзэсгэлэн</b></li> <li>Хэзээ : 3.8~3.10</li> <li>Хаана : ЭКСКО төв</li> <li>Харилцах утас : (Т)+82-53-803-3341 (E)choonggi@korea.kr (H)http://www.previewin.com/</li> </ul>                                                                     |                                                                                                                                                                                                                           | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Дэгү хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Дэгү-Загварын үзэсгэлэн</b></li> <li>Хэзээ : 3.8~3.10</li> <li>Хаана : ЭКСКО төв</li> <li>Харилцах утас : (Т)+82-53-803-3352 (E)kj70@daegu.go.kr (H)http://www.daegufashionfair.com</li> </ul>                                                                                                  |                                                                                                                                                                                                                                     |
| 15                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                            | 17                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 18                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Дэгү хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Дэгү-Заалан дахь хөнгөн атлетикийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2017</b></li> <li>Хэзээ : 3.19~3.25</li> <li>Хаана : Хөнгөн атлетикийн хөгжлийн төв</li> <li>Харилцах утас : (Т)+82-53-790-4125 (E)heatherj@korea.kr (H)http://www.daegufashionfair.com</li> </ul> | 23                                                                                                                                                                                                                                                                                                         | 24                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 25                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 29                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 30                                                                                                                                                                                                                                                                                                         | 31                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Дэгү хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Олон улсын ногоон эрчим хүч экспо 2017</b></li> <li>Хэзээ : 4.5~4.7</li> <li>Хаана : ЭКСКО төв</li> <li>Харилцах утас : (Т)+82-53-803-5911 (E)jangych@korea.kr (H)www.Energyexpo.co.kr</li> </ul>                                                                        | 6                                                                                                                                                                                                                                                                                                          | 7                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 8                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 12                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 13                                                                                                                                                                                                                                                                                                         | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Жолланам муж/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>"VISIT ALTAI" олон улсын аялал жуулчлалын форум</b></li> <li>Хэзээ : 4.14~5.7</li> <li>Хаана : Вуанду боомт Далайн эргийн парк</li> <li>Харилцах утас : (Т)+82-61-286-6921</li> </ul>                                                                                                       | 15                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 19                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Дэгү хот/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Дэгү-Олон улсын нүдний шилний үзэсгэлэн</b></li> <li>Хэзээ : 4.20~4.22</li> <li>Хаана : ЭКСКО төв</li> <li>Харилцах утас : (Т)+82-53-803-3361 (E)hjjg7733@daegu.go.kr (H)http://www.diops.co.kr</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Алтайн хязгаар/ОХУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>"VISIT ALTAI" олон улсын аялал жуулчлалын форум</b></li> <li>Хэзээ : 4.21~4.30</li> <li>Хаана : Алтайн хязгаар</li> <li>Харилцах утас : Алтайн хязгаарын Аялал жуулчлал, амралт, бүс, олон улсын харилцааны яам (Т/Ф) +7-3852-20-10-31 (E) priem@altur22.ru, tourism_22@mail.ru</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Ангилал : Гёнсанбүг муж/БНСУ</li> <li>Арга хэмжээний нэр : <b>Ысон-Дэлхийн цаасан шувууны наадам</b></li> <li>Хэзээ : 4.22~4.24</li> <li>Хаана : Вичон эко гол</li> <li>Харилцах утас : (Т)+82-54-830-6096 (E)dlwogns99@korea.kr (H)http://www.worldkitefestival.kr/</li> </ul> |
| 26                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 22                                                                                                                                                                                                                                                                                                                     |



# Япон улсын Шиманэ муж

Япон улсын баруун хэсгийн далайн эрэгт орших Шиманэ муж үзэсгэлэнт байгальтай, уур амьсгал нь зөөлөн дулаан байдаг. Газар нутаг нь зүүнээс баруун тийш 230 км үргэлжлэх ба эх газраас 40-80 км алслагдах газарт Оки арал байдаг. Хүн ам нь 690.000.

Аж үйлдвэрийн хувьд тусгай ган төмөр үйлдвэрлэл, мэдээллийн технологийн аж үйлдвэр түлхүү хөгжсөн. Шиманэ муж үйлдвэрлэл, мэдээллийн технологи (IT), нутгийн нөөцөд тулгуурласан аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд мужийн их сургууль болон бусад дээд боловсролын байгууллагуудад холбогдох чиглэлийн боловсон хүчнийг бэлтгэн шинэ технологи гаргахын тулд мужийн аж үйлдвэр, технологийн төвтэй хамтран ажиллаж байна. Сэтгүүлийн энэ дугаарт Шиманэ мужид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргахад нутгийн захиргааны зүгээс үзүүлэх дэмжлэг, бодлого зэргийн талаар танилцуулж байна.






Тайландад үзэсгэлэнд оролцож буй нь 2



Бизнес аялал 1



Бизнес аялал 2



Шиманэ мужийн бизнесийг дэмжих алба

### Шиманэ мужийн компаниудыг гадаадад үйл ажиллагаа явуулахад үзүүлэх дэмжтэг



Шиманэ мужийн захиргаанаас нутгийн аж ахуй эрхлэгчид гадаадын зах зээлд үйл ажиллагаа явуулахад анхан шатнаас нь авахуулаад бизнесийн үйл ажиллагаа явуулах хүртэл бүхий л үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.

Шиманэ мужийн захиргааны Аж үйлдвэрийг хөгжүүлэх хэлтэс 2011 оноос эхлэн жижиц, дунд үйлдвэрүүдийг гадаадын зах зээлд гарахад туслах үүднээс семинар зохион байгуулах, бизнес аялал хийх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд 2013 оноос эхлэн уг ажлын хүрээнд гадаадын зах зээлд гарах төлөвлөгөөг боловсруулах, боловсон хүчнийг хөгжүүлэх, гадаадад худалдаалах үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлж байна.

Тухайлбал гадаадын зах зээлд гарах төлөвлөгөөг боловсруулахад бизнесийн зөвлөгөө өгөх, судалгаа хийх, компани байгуулах зардлыг тооцоолж өгдөг. Гадаадад худалдааны үйл ажиллагаа явуулах арга замыг судлахад Тайланд, Индонези зэрэг улсуудад болдог олон улсын үзэсгэлэнд Шиманэ мужийн павилион гаргах, Японы дотоодод үйл ажиллагаа явуулдаг гадаадын аж ахуй эрхлэгчидтэй бизнес уулзалт хийхэд зуучлах, Шиманэ мужийн компаниуд гадаадад худалдааны үйл ажиллагаа явуулах арга замыг судлахад гарах зардалд дэмжлэг үзүүлдэг.

Мөн 2014 оны 9 дүгээр сард Тайланд улсын Бангкок хотноо “Шиманэ мужийн бизнесийг дэмжих алба”-ыг байгуулан Азийн бүсэд үйл ажиллагаа явуулах компани болон гадаадад үйл ажиллагаа явуулж буй компаниудад зөвлөгөө өгч байна. Жилд 100 гаруй удаагийн зөвлөгөө өгч худалдааг өргөжүүлэх, газар дээр нь зах зээлийн судалгаа хийх, гадаадад үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль эрх зүй, татварын асуудалд тусалдаг.

Цаашид гадаадад үйл ажиллагаа явуулж буй компаниудын менежментийг авч явах боловсон хүчнийг хөгжүүлэх болон тухайн нөхцөл байдалд тохирох дэмжлэгийг үзүүлэх болно.





Шиманэ мужийн алдартай хоол-Ицму суба

### Шиманэ мужид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаадад худалдаалах үйл ажиллагаа

Шиманэ мужийн захиргааны Брэнд хариуцсан хэлтэс болон Худалдааг идэвхжүүлэх, дэмжих албанаас мужид үйлдвэрлэсэн газар тариалан, далайн бүтээгдэхүүн, боловсруулсан бүтээгдэхүүн зэргийг гадаадын зах зээлд гаргахын тулд чармайн ажиллаж байна. Дотоодын зах зээлд эрэлт багасч байгаатай холбогдуулан бизнес эрхлэгчдийг гадаадын зах зээлд үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлж байна. Одоогийн байдлаар голчлон Америк, Европын орнуудын бизнесийн зах зээлд үйл ажиллагаа явуулахад анхаарч байна. Тухайлбал гадаадын бизнес эрхлэгчдийг Шиманэ мужид урин мужийн хүнсний компаниудыг танилцуулан бизнес уулзалт зохион байгуулдаг. Бизнес уулзалтын үр дүнд хүнсний компаниудтай хамтран гадаад улсад болдог олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох юмуу Шиманэ мужид үзэсгэлэн зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг явуулж, Шиманэ мужийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргахад тууштай анхаардаг.

Урьд нь гадаадад ажиллаж, амьдардаг япон хүмүүст зориулан голчлон худалдаалдаг байсан хүнсний бүтээгдэхүүний эрэлт ихэсч байгаатай холбогдуулан гадаад хүмүүст ч зориулан худалдаалах зорилт тавьсан. Нэн ялангуяа органик материалаар уламжлалт аргаар үйлдвэрлэсэн цуу, цай зэрэг бүтээгдэхүүний эрэлт өндөр байна. Цаашид ч тус мужаас нутгийн хүнсний бүтээгдэхүүнийг гадаадад таниулан сурталчлахын тулд мужийн бизнес эрхлэгчидтэй хамтарч ажиллах бодлого барих болно.



Шиманэ мужид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргах тухай бизнес уулзалт



Шиманэ мужид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн





Шиманэ мужийн бэлгэдэл-цээнэ цэцэг



Тайвань улсад цээнэ цэцгийн сурталчилгааг хийсэн нь



Владивосток хотод болсон худалдааг идэвхжүүлэх арга хэмжээ

## Цээнэ цэцгийн экспорт

Шиманэ мужийн бэлгэдэл болох цээнэ цэцгийг 1963 оноос эхлэн гадаадад экспортолох болсон. Жилдээ тарьсан цэцгийн дөрөвний нэгийг гадаадад экспортолдоггоос одоогийн байдлаар Нидерланд, Америк зэрэг орнуудад 200 000 ширхэг цээнэ цэцгийг экспортолдоод байна.

20 жилийн өмнөөс цэцэг дэлгэрэх хугацааг тохируулах технологийг хөгжүүлж тусгай патент авсан. Уур амьсгалын хувьд Японоос ялгаатай гадаад улсад цээнэ цэцгийг тарихад уг технологийг ашигладаг. Сүүлийн үед Тайвань Орост худалдаалж байна. Түүнээс гадна мужийн газар тариалангийн ажилтан гадаадад очиж, цэцэг тарих арга технологийг заадаг. Цээнэ цэцэг сонирхох гадаад хүмүүстэй шууд харилцах нь жуулчин татах, соёлын харилцааг явуулах зэрэг мужийн зүгээс явуулах үйл ажиллагаанд том хувь нэмэр болдог. Цээнэ цэцгийг чимэглэлийн зориулалтаар ч ашиглах ба түүгээр дамжуулан цайны соёл, Японы цэцэрлэгжүүлэлтийн соёлтой танилцахад ч дөхөмтэй. Орост зуслангийн газартаа цэцэг тарьж тохижуулдаг тул тэдний эрэлтэд таарах сортын цээнэ цэцгийг экспортолдог. Цаашид Японыг төлөөлөх цэцгийн нэг болох Шиманэ мужийн цээнэ цэцгийг дэлхийд таниулах шинэ замыг нээх болно.




# Ази Номхон далайн хотуудын дээд хэмжээний хурал болон хотын захирагч нарын форум 2017(2017APCS)

Энэхүү хурлыг БНСУ-ын Дэжон хот, Австрали улсын Брисбен хот хамтран 9 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Дэжон хотноо зохион байгуулна. “Ази Номхон далайн ирээдүйн хөгжлийн шинэ чиг хандлагыг тодорхойлох нь” сэдэвт уг форумд 100 хотын захирагч, бизнесийн төлөөлөл, хот хөгжлийн мэргэжилтэн, залуучуудын төлөөлөл зэрэг 1500 гаруй хүн оролцоно.

## Форумын зорилго

Ази Номхон далайн хотуудын дээд хэмжээний хурлыг 1996 онд Австралийн Брисбен хотноо зохион байгуулсан бөгөөд хотын менежмент, төлөвлөлтийн салбарт Ази номхон далайн бүсийн бизнес, төр захиргаадын форум болсон. Энэ удаагийн хурлын хугацаанд мэдлэг солилцох, хотын асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаарх туршлагаа харилцан солилцох, Ази Номхон далайн бүсийн хотуудын менежментийг сайжруулах арга замын талаар хэлэлцэнэ.





## Гол хөтөлбөр

### <Нээлтийн илтгэл, хурал>

Дэлхийн нэртэй эрдэмтэн, мэргэдийг урьж оролцуулан “Шинжлэх ухаан ба технологид суурилсан хотын шинэчлэл” сэдвээр чиг хандлага ба зорилтыг тодорхойлно. Дараах хүмүүс нээлтийн илтгэлийг тавина.

|                   |                                                                                                                                                     |
|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Чер Блэйр</b>  | Чер Блэйр санг үүсгэн байгуулагч<br>Азийн эмэгтэйчүүдийн их сургуулийн хүндэт захирал<br>Дэлхийн эмэгтэй бизнес удирдагчдын хорооны дэд ерөнхийлөгч |
| <b>Жерад Коэн</b> | JIGSAW компаний захирал<br>Гүүгл стратегич                                                                                                          |
| <b>Томас Фрэй</b> | Дабинчи судалгааны газрын захирал<br>Ирээдүйн талаар судлаач эрдэмтэн<br>("Ирээдүйтэй ярилцагч" номны зохиолч)                                      |

### <Дагалдах хурал>

Дараах 4 сэдвээр олон улсын байгууллага, төр засаг, боловсролын судалгааны байгууллага, иргэдийн төлөөлөл илтгэл тавина.

- Шинжлэх ухаан, технологид суурилсан хотын шинэчлэл (Innovating Cities through Science and Technology)
- Бизнесийн үйл ажиллагаагаар хотыг дахин идэвхжүүлэх (Revitalizing Cities through Vibrant Business Activities)
- Хотын тогтвортой хөгжлийн стратеги (Achieving Sustainable City Solutions)
- Соёл, урлагаар хотын орчныг сэргээх (Recreating Cities through Art and Culture)

### <Хотын захирагч нарын форум>

Хотын төлөөлүүд сэдэвтэй холбоотой төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэхээс гадна хотын захирагч нарын хооронд хамтын ажиллагаа, нөхөрлөлийг нэмэгдүүлж, Ази Номхон далайн орнуудын хотын дээд хэмжээний энэхүү хурлаас “Хамтарсан мэдэгдэл” гаргана.

### <Залуучуудын форум>

18-30 насны залуу удирдагч, оюутан, мэргэжилтнүүд Ази Номхон далайн орнуудын хотуудын талаар санал бодлоо хуваалцаж, ирээдүйн хотын шинэ зорилтыг эрэлхийлнэ. 4 дэд сэдэвтэй холбогдох хотын асуудлыг урьдчилан хэлэлцэж онлайн болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан асуудлыг шийдвэрлэхийн тулд урьдаас хэлэлцэх ба энэхүү форумд оролцогчид тайлан гаргахаас гадна шилдэг илтгэгчид шагнал олгоно.

### <Үзэсгэлэн, бизнес уулзалт>

Хурлын үеэр оролцогчид хот, компаниудын сурталчилгааны танхим ажиллуулахаас гадна бизнес уулзалт, хөрөнгө оруулалтын танилцуулга зэрэг хөтөлбөр зохион байгуулна.



16 NEAR NEWS Vol. 73





## <Тусгай байр>

# Даймон ахлах сургуулийн сурагч Икэда Аюү Олон үндэстнээс бүрдэх Сингапур улсаас сурсан зүйл

Ний нуугүй хэлэхэд би Зүүн хойд Азийг сайнаар боддоггүй. Учир нь Хятадын агаарын бохирдол, хог хаягдлын асуудлаас гадна бага сургуулийн биеийн тамирын талбайд ашигладаг резинэн материал сурагчдын эрүүл мэндэд хор нөлөө учруулсан гэх мэдээг сонссон. Өмнөд Солонгосын боловсролын салбарт Японы эсрэг үзэл суртал суулгах, Дугду арлын төлөөх булаацалдаан, солонгос охид хүүхнүүдийг Япон цэргийн бэлгийн боолчлолд ашиглаж байсан зэрэг асуудал, Хойд Солонгосын цөмийн пуужин хөөргөсөн хийгээд япон иргэнийг барьцаалсан явдал, түүнчлэн Монголын цөлжилт, агаарын бохирдол, Орос ба Японы газар нутгийн маргалдаан гэх мэтийн асуудлууд байдаг. Тэгээд ч Японтой сайн харилцаатай улс цөөхөн гэлтэй. Телевизийн мэдээгээр ч иймэрхүү мэдээлэл гардаг тул Японы ахлах сургуулийн сурагчдын дийлэнх нь Зүүн хойд Азийн улсуудын талаар таагүй бодолтой байдаг. Би Зүүн хойд Азийн улс орнуудад очиж байгаагүй тул үнэндээ сайн мэдэхгүй ч саарын хажуугаар сайн зүйл ч байгаа гэж бодож байна.

Би Сингапурт 3 удаа очиж байсан. Ээж маань багшлангаа Сингапурт амьдардаг байсан бөгөөд бага наснаасаа Сингапурын талаар байнга сонсдог байсан. Сингапурт үндэс гарал, шашин, соёл өөр малай, хятад, энэтхэг зэрэг олон үндэстэн амьдардаг. Хятад хотхонд очиход хиндү шашны сүм харагдах бол бяцхан Энэтхэг хэмээх хотхонд очиход хятад маягийн буддын сүм ч харагдана. Исламын шашны сүмд жуулчид олноор чөлөөтэй хөлхөх ба тэнд би тэр газрын хүмүүсийн адилаар мэндэлж байсан. Тэнд олон янзын шашин шүтлэгтэй хүмүүс эвтэй найртай, амар амгалан байв. Сүүлийн үед исламын шашинтай холбоотой асуудлууд гарч буй бөгөөд шашин өөр бол хоорондоо ойлголцохгүй гэж бодогдох ч Сингапурын тэр дүр зураг бидэнд харилцан ойлголцол, харилцааг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.

Сингапурын гудамж маш сайхан. Тэнд гудамж талбайгаа цэвэрхэн байлгахын тулд хэрэв хог хаявал торгууль ногдуулдаг. Цэвэр гудамж

талбайд харилцан адилгүй үндэсний хувцастай хүмүүс хоорондоо халуун дотноор хөөрөлдөнө. Төрсөн газар, эх хэл, амьдралын хэв маяг, үзэл бодол өөр ч хоорондоо дотно хандах тэр байдлыг харахад гайхмаар. Эсрэгээр Японы хувьд бие биенээ ойлгох байдал учир дутагдалтай. Буддын болон исламын сүм хийдэд хүмүүс чөлөөтэй орж гаран мөргөн залбирч байгааг харахад жижигхэн улсад олон үндэстэн эв найртай амьдрахыг харахад сайхан санагдсан. Сингапур бол амьдрахад сайхан орон гэж санагдахын зэрэгцээ Сингапур хүмүүсийг ойлгоход ч асуудалгүй санагдсан. Хүн бусдын муу талыг харахад мууг нь л түрүүлж бодох гэдэг хандлагатай байдаг тул муу тал нь харагдаж байсан ч сайн талыг нь олж харах гэж хичээх хэрэгтэй. Энэ нь хүмүүсийн харилцаа төдийгүй улс хоорондын харилцааг сайжруулахад тустай.

Одоо миний хувьд Зүүн хойд Азийн талаар сөрөг бодолтой байна. Гэсэн хэдий ч цаашид эдгээр улсуудын гэрэл гэгээтэй талыг харж мэдэхийг хүсч байна. Орчин үед интернетийн тусламжтай дэлхий ертөнцтэй холбогдон мэдээллийг цуглуулахаас гадна өөр улсын хүмүүстэй санал бодлоо ч солилцож болно. Би тэдэнтэй харилцахад шаардлагатай англи хэлний чадвар дутмаг. Гадаадад япон хэл мэддэг хүмүүс их ч олон улсын хүмүүстэй харилцахад дэлхийн нийтлэг хэл болох англи хэлээр ярьдаг байх шаардлагатай. Би цаашид олон улсын харилцааны ангид элсэн дэлхийг Японтой холбох гүүрийн үүрэг гүйцэтгэхийг мөрөөддөг. Би юуг хийж бүтээхийг одоохондоо хэлж мэдэхгүй ч жижиг зүйл ч болтугай хийж бүтээхийг хүсч байна. Зүүн хойд Азийн орнууд улс төр, эдийн засаг, байгаль орчны салбарт хамтын ажиллагааг түлхүү явуулаасай гэж бодож байна. Тиймийн тулд миний зүгээс эхлээд англи хэлээ сайн сурч эзэмших нь анхны алхам гэж үзэж одооноос хичээж байна.

## &lt;Тусгай байр&gt;

## Зүүн хойд Азийг таньж мэдэцгээе!

## Пухан ахлах сургуулийн сурагч Шим Сэ Юн

Дугду арлыг өөрийн гэж үзэх Японы санаархал, Курилын арлыг өөрсдийн эзэмшил гэж үзэх Япон, Оросын маргаан, Япон ба Хятад, Тайваны хооронд орших Сэнкакү арлын маргаан зэрэг нь Азийн зүүн хойд хэсэгт орших улсуудын асуудал юм. Зүүн хойд Азид Солонгос улсаас гадна Хятад, Япон, өргөн утгаар Тайваныг хамруулж болно. Би Солонгос, Хятад, Япон улсыг голчлон танилцуулъя.

Зүүн хойд Азийн орнууд эртнээс нягт харилцаатай байсан. Хятадаар дамжин орж ирсэн соёл Солонгосын хойгоор дамжин Японд түгсэн. Мөн Японы соёл Солонгосын хойг болон Хятадад ч түгж байсан. Мэдээж сайны хажуугаар саар зүйл ч байсан. Эртний болон дундад зууны үед Хятад улс Солонгосын хойгт довтолсон хийгээд Япон улс Солонгосын хойг болон Хятад улсын газар нутагт шунасанаас үүдэлтэй аймшигтай дайныг мартахын аргагүй. Одоо ч Зүүн хойд Азийн улсууд ойлголцоход ээдрээтэй байгаа бөгөөд өөрийн орны ашгийг л чухалчилдаг.

Энэ мэт асуудлыг шийдвэрлэхийн тулд Зүүн хойд Азийн улсуудын талаар ихийг мэдэж ойлгох нь чухал. Эхлээд Зүүн хойд Азийн улсуудын нийтлэг болон ялгаатай зүйлийг мэдэх хэрэгтэй. Эдгээр улсуудын нийтлэг зүйлийг мэдэх нь Зүүн хойд Азийн улс хоорондын дотно харилцааг нэмэгдүүлж хоорондоо дайсагнах сэтгэлийг арилгах бөгөөд өөрсдийн ялгаатай талыг мэдэх нь бусдыг ойлгон хүндлэх арга юм.

Зүүн хойд Азийн орнуудын нийтлэг зүйлд Буддын шашин болон Күнзийн сургаалийг дурдаж болно. Буддын шашин нь удаан хугацааны турш Зүүн хойд Азийн улсуудын оюун санаа, сүсэг бишрэлд нөлөөлж байсан. Күнзийн сургааль нь Солонгос, Хятад, Япон 3 улсын удирдах аргад асар их үүрэг гүйцэтгэсэн бөгөөд одоо ч нөлөө үзүүлсээр байна. Мөн ханз үсэг бичиг эдгээр улсуудын бас нэг нийтлэг зүйл юм. Солонгосын Сэжун их хаан хангыл бичгийг зохиохоос өмнө эдгээр гурван улс бүгд ханз бичиг үсгийг хэрэглэдэг байсан. Хангыл бичиг гарсанаас хойш одоо ч Япон, Солонгост ханз үг их үлдсэн байдаг. Ялгаатай зүйлийг дурдвал өнгөрсөн үеийн түүхэнд эдгээр гурван улсын байр суурийг хэлж болно. Хятад улс өөрийн хүчинд тулгуурлан Солонгос ба Японы тусгаар байдлыг хүлээн зөвшөөрөнгөө алба гувчуур авдаг байсан. Солонгос улс Хятад улстай харилцангаа илүү, сайн зүйлийг нэвтрүүлэхийн зэрэгцээ хөрш зэргэлдээ улсуудтай найрсаг харилцаж байсан. Япон улс Солонгос улсаар дамжуулан гадны сайн зүйлийг авч байсан мөн Хятад улстай ч шууд харилцаж байсан. Гэхдээ арлын улс болохоор хөгжлөөр хоцорч эхлэхэд үргэлж эх газар руу нэвтрэхийн тулд хөрш зэргэлдээ улсад дайн

өдөөсөн.

Буддын шашин, Күнзийн сургааль, ханз гэх нийтлэг зүйл нь эдгээр гурван улсын ард түмний соёлыг нэгтгэх үндэс болох юм. Солонгосын К-поп, Японы анимаци нь дээрх гурван улсын ард иргэдийн сонирхдог зүйл гэдгийг баталсан. Энэ мэт соёлыг бий болгох нь миний үеийн хүүхдүүд болон 20 настнуудын хичээл зүтгэл чухал. Учир нь хүүхэд залуучууд олон нийтийн сүлжээ гэгч орон зайгаас хальсан мэдээллийн хэрэгслүүдэд дасан зохицож хийх зүйлдээ шамдаж чадна. Энэ гурван улсын арав, хорин настнууд л хамгийн түрүүнд тоглоом, дуу хөгжим, бүжгийн салбарт шинэ соёлыг бий болгоход их нөлөөтэй.

Түүх, ард түмний үзэл санааны ялгаагаар гүн үлдсэн дургуйцэх сэтгэлийг ард түмний хичээл зүтгэлээр өөрчлөхөд учир дутагдалтай юм. Гурван улсын Засгийн газраас энэ мэт ялгаагаар дамжуулан өөрсдийн эрх ашгийг хадгалахын тулд Японы түүхийг гуйвуулах зэргээр улс төрд түүх ба ард түмнийг ашиглахыг хатуу хориглон үүнийг зөрчих тохиолдолд ард иргэд тэдний байдлыг шүүмжлэн шийтгэх хэрэгтэй. Цаашид засгийн газраас түүхэн гуйвуулгыг засахын тулд хичээх хэрэгтэй бөгөөд ард иргэд өөр улсын ард түмний онцлог шинжийг ойлгон хүндлэх хэрэгтэй.

Одоо Зүүн хойд Ази бол дэлхийн хүчирхэг орнууд төвлөрсөн бүс бөгөөд бүсийн улс орнууд хоорондын зөрчил маргаан дэлхийн хэмжээний асуудал ч болох талтай. Тэр тусмаа Хойд Солонгостой холбогдох асуудлууд ч байгаа тул зөрчил мөргөлдөөнийг хурдан арилгах хэрэгтэй. Цаашид Зүүн хойд Азийн улс хоорондын харилцаанаас шалтгаалан дайн ч гарж болох мөн энхтайван ч оршин тогтнож болох тул биднээс их зүйл шалтгаална. Зүүн хойд Азийн улс орнуудыг авч явах бидний үе бие биенээ ойлгон хүндлэх юм бол энх тайван биднийг хүлээж байх болно.



## &lt;Тусгай байр&gt;

# Орос улсын ирээдүй-Миний нүдээр

## Хабаровск хязгаарын Панков дунд сургуулийн сурагч Николайчук Никита



ОХУ-ын ирээдүй бодитой, ухамсартай эрин үе руу алгуурхан аажим, аажмаар шилжиж буй дэлхийн агуу төслийг би санал болгож байна. Ёс суртахуун, оюун санааны болон эдийн засгийн хүчин чадал нь улс орны ирээдүйд чухалаар нөлөөлдөг.



Москва хотыг ихэвчлэн хуучинсаг үзлийн бэлэг тэмдэг "Гурав дахь Ром" хэмээн нэрлэдэг.

Ромын эзэнт гүрнээс Византи, мөн Византиас Москва хүртэл үнэн алдартны итгэлийн бамбар ард түмний хувь заяаг тодорхойлж байсан ба мянга гаруй жилийн түүхтэй Орос улсын энх тайван, эв найрамдал, итгэл хайр, нинжин сэтгэл, ажил хөдөлмөрийн өргөө болсон Москва хот ОХУ-ын төрийн ёс

суртахууны бодлого, улс орны хөгжлийн үндэс суурийг тавьсан. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэмжээс цаг хугацааны тухай богинохон түүхээр ОХУ-ын одоо ба ирээдүйн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлье.

Өнгөрсөн үе бол бидний оршин тогтнохын үндэс, одоо үе бол бидний ухамсарыг тодорхойлогч салаа мөчир нь бөгөөд харин ирээдүй бол зөвхөн цэцэглүүлэх ёстой навч юм. Хэдийгээр зуувандуу хилэн навч нь үржил шимтэй хөрсөнд ургасан шүүслэг модны зүгээр л салаа мөчир шиг харагддаг ч өнгөрсөнөө хүндэтгэж, одоогоороо бахархдаг улсыг минь гэрэлт ирээдүй хүлээж байна.

Орос улсын туулж өнгөрүүлсэн түүхээс эргэн дурсъя: - Куликовын тулаанд амжилттай дайтсан Оросын ард түмэн, 1812 онд Бородини тулаанд амь эрсэдсэн эрэлхэг зоригт цэрэг эрс, 20-р зууны цус урсгасан их дайны баатрууд, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө амь биеэ харамгүй зориулсан бүх хүмүүсээ дурсан санаж байна.

ОХУ бол олон ястан үндэстний өлгий юм. Оросын соёл иргэншил нь түүхийн явцад хэзээ ч салж задрахгүйгээр эвлэлдэн нэгдсэн олон үндэстний өөр өөрийн гэсэн өвөрмөц хэл, соёлтой салшгүй холбоотой. Тиймээс миний бодлоор манай улсын ирээдүй олон үндэстнүүд соёл, эдийн засгийн аль ч салбарт харилцан бие биенээ баяжуулахад үндэслэн хөгжинө. Агуу их, үнэ цэнэтэй ирээдүйг бүтээхэд ОХУ-ын нэр төр, эв нэгдэл итгэл сэтгэлийн хүч чадал нь оюун санаа, ёс суртахууны үндсийг тодорхойлох болно.

Орос улсын дараагийн үеийг би хэрхэн харж байна вэ?

Би итгэл, нэр төр, ёс суртахууны нийтлэг, тодорхой ойлголтод үндэслэн нийгэмд хүн бүр өөрийгөө бахархалтайгаар би эр хүн, эмэгтэй хүн хэмээн дуудах боломжтой шударга нийгмийг харж байна. Би хонхон дуугаар өглөө бүрийг зарлан тунхаглах бөмбөгөр алтан оройтой сүм, хайр сэтгэл, үнэнч байдал, харилцан итгэлцэлд тулгуурладаг хүчирхэг гэр бүлүүд нь хөгжилдөн алхаж буй чулуун гудамжтай том хотуудыг харж байна.

Би найз нөхөд, гэр бүлийнхнээсээ Орос улсын ойрын арван жилийн ирээдүйг хэрхэн харж байна вэ? хэмээн асуухад: -Тэд бүгд л надад нэг л зүйлийг хэлсэн!

Би энэ бүх агуу хүсэл мөрөөдөл нь бодит биелэлээ олох болно гэдэгт үнэхээр итгэж байна. Учир нь Орос орны тухай үүнээс өөрөөр төсөөлөх ч аргагүй юм.

ОХУ-ын зохиолч, яруу найрагч Эдвард Асадов өөрийн улсын өнгөрсөн

үеийн талаар дүрслэхдээ "Орос улс илдээр эхлээгүй/Эхэлж илд далайгаагүй гэсэн утга/" гэсэн гайхамшигтай үгийг хэлсэн байдаг. Энэ үгэнд манай улсын ирээдүйн талаарх далд утга агуулагдаж байна. Орос улс хэзээ ч дайныг эхэлж өдөөж байгаагүй бөгөөд байх ч үгүй. Энэ бол манай улсын агуу их хүч чадал юм. Дэлхийн 2 тивийг хамран орших Орос улс дорно, өрнийн тэнцвэр юм. ОХУ тэнцвэрийг хадгалах гол зорилготой байсан. ОХУ-ын одоогийн болон ирээдүйн дэлхийн хэмжээний нэн тэргүүний хамгийн чухал зорилтын нэг нь газрын тос, байгалийн хий зэрэг ашигт малтмалыг орчин үеийн, өндөр технологиор боловсруулах тогтолцоог бий болгох явдал юм. Газрын тос бол эрчим хүч, хөнгөн үйлдвэрлэлийн бараг бүх салбарт гол бүрэлдэхүүн хэсэг болдог.

19-р зуунд манай үндэсний, дэлхийд нэртэй эрдэмтэн Менделеев: "Түүхий газрын тосны арилжаа бол мөнгөө зууханд шатааж байгаатай адилхан зүйл юм" гэж хэлсэн байдаг. Тийм ч учраас 21-р зууны дунд үед анх удаа түүхий газрын тосны импорт биш харин газрын тосны бүтээгдэхүүн болоод байгалийн хийг өндөр технологиор боловсруулсан нь ОХУ-ын эдийн засгийг хурдацтай хөгжүүлэхэд хүргэсэн. Үүний зэрэгцээ бид нисэх онгоц, усан онгоц, микроэлектроник болон сансрын үйлдвэрлэлийн салбарт пуужингийн үйлвэрлэлийг хурдацтай хөгжүүлэх ёстой байлаа. Энэ бүх зүйлгүйгээр эдийн засгийн хувьд хөгжингүй улсын нэг болох боломжгүй юм.

Өнөөдөр бид дэлхийн гео-стратегийн шилжилтийг харж болно. Өмнө нь Геополитик Европд болон Европийн төв хэсэгт төвлөрч байсан бол одоо Ойрхи Дорнод, Төв болон Зүүн Өмнөд Азид төвлөрч байна. Тиймээс ОХУ-ын эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол нь Алс Дорнод болон Сибирь болоод байна. Зуу гаруй жилийн өмнө ОХУ-ын төрийн зүтгэлтэн Николай Николаевич Муравьев Амурский: "ОХУ- Дорнодоос эхлэлтэй ..." хэмээсэн байдаг. Өнөө үед ОХУ-ын Холбооны хуулийн дагуу Алс Дорнод нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх нутаг дэвсгэр болоод байна. Алс Дорнодод тус улсын хамгийн орчин үеийн "Восток" сансрын хөлгийг үйлдвэрлэж байна. Алс Дорнод бол ОХУ-ын ирээдүйн эхлэл юм. Өргөн уудам газар нутагтай ба гайхалтай үзэсгэлэнт байгалтай, идэвхтэй, чадварлаг сая сая мэргэжилтэнүүд таныг хүлээж байна. Асар их баялагийн нөөцтэй Оросын Дорнод хэсэг гадаадын найдвартай түншүүдэд үргэлж нээлттэй байна. ОХУ-ын Дорнод нутагт сэтгэхүй болон эв нэгдлийн зорилго нэгтэй, богино хугацаанд харилцан ашигтай хөгжлийг урьдчилан тооцоолдог, нөхөрсөгөөр гараа сунгаж эдийн засгийн дэмжлэг үзүүлэх түншлэгчид ямар ч цаг үед нээлттэй байдаг.

ОХУ бол зөвхөн газрын зурагт дэлхийн бөмбөрцгийн хоёр хэсэгт оршдог цорын ганц улс биш маш өвөрмөц гүрэн юм. Бид Дорнод, Европийн аль алиных нь соёл, уламжлалыг дээдлэн хүндэтгэж, бүх улс орнуудын харилцаанд талархаж байдаг билээ. Мөн улс төрийн удирдагчдын дийлэнх нь ижил зорилго дээр анхаарлаа хандуулж дэлхий ертөнцийн гэрэлт ирээдүйг бүтээх цэвэр ариун итгэл, хайр, ойлголцол үр тариа шиг дэлгэрэн бид хамтдаа урагшилж ОХУ-ын тусламжтайгаар сайн сайхан ертөнцийг бүтээцгээе.

# The Association of Northeast Asia Regional Governments



**Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо**

The Association of Northeast Asia Regional Governments

**Хаяг.** Кёнсанбүг муж, Пухан хот, Намгү Жигугну 394(Жигугдун 601) Пухан Техно парк 3 давхарт

**Утас.** +82-54-223-2384 **Факс.** +82-54-223-2309 **E-mail** near@neargov.org **Website** www.neargov.org